

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Чойжилсүрэн	Дугаар	L195
Оршин суугаа аймаг	Завхан	Оршин суугаа сум	Тосонцэнгэл сум
Төрсөн газар	Тосонцэнгэл сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Байшинтын хийд, Шумуултайн хүрээ	Сүм хийдийн дугаар	ЗАБЛ 042, ЗАБЛ 039
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 22	Ярилцлага авсан хүн	С.Билэг-Өрнөх

Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Байшинтын хийд, Шумуултайн хүрээ

Чойжилсүрэн: За тэгэхээр манай энэ Засгийн хошуу гэж байсан байгаа юм. Тэгэхээр Засгийн хошууны хүрээ гэж байсан , энд. Байшинтын хүрээ гэж байсан, энэ хойхно жалгат. Дунд шумуултайн хүрээ гэж бас жалгат нэг хүрээ байсан байгаа юм. Тэр хүрээг бол би мэдэхгүй юм билээ. Тэр Байшинтын хүрээ гэдэг дээр би аавыгаа дагаж очиж маанинд хурж хуралд хурж дагаж явсан юм. Чухам юу уншиж, яаж байсныгаа бол мэдэхгүй юм, бага байсан. Энэ Дунд шумуултайн хүрээ гэдэг бол 75 цам харайдаг их том хүрээ байсан юм гэнэ лээ. Би майдар мөргөхөд эгчийгээ дагаж, майдар үзэж явсан хүн дээ. Тэгэхэд их том хүрээ байсан. Тэгээд тэрнээс хойш мянга есөн зуун хэдэн онд нь юм, гучин хэдэн онд нь юм уу. Энэ хүрээг тэр хорин хоёр оны эсэргүү гэдэг үед хүрч ирж шатаасан байгаа юм. Тэр хуучин одоо Завхан аймаг гэж байгаагаас цэргийн хороо хүрч ирж, шарын цэрэг улааны цэрэг гэж хоёр хувагдаж байлдаж байсан. Тэгээд шарын цэрэг нь хошуу хүрээнд дээр энд бөөгнөчихсөн, энд байж байсныг нь Завханаас тэр цэргийн хороо хүрч ирж байлдаж шатаасан юм билээ л дээ, энэ хүрээг. Тийм түүхтэй домогтой юм билээ. Зүгээр энийг бол сайн мэддэг улсууд нь ярьж байсан л даа. Тэгэхлээр манай аав бол лам хүн байсан. Би тэр аавыгаа дагаж Байшинтын хүрээнд дээр хуралд явж л байсан. юм. Зүгээр би энэ Хошуу хүрээнд бол майдар л үзэж байснаас өөр юм мэдэхгүй. Тэр майдар эргэнэ гэдэг бол их олон цам харайж янз бүрийн юм болж байхыг их үзсэн л дээ. Нэг хоёр чиг дахиж үзсэн байх, тэрийг би.Тэгж боддог юм, тэгээд энэ Хожуулын хүрээ гэж байсан байгаа юм. Харганы хүрээ гэж байсан юм гэнэ лээ. Тэд нарыг нарийн мэдэхгүй юм. Зүгээр миний мэдэх бол яахав тийм л юм даа. Зоч, лүйжин тавьж явдаг улсууд байсан юм. Тэрийг мэднэ. Намайг майдарт мөргөөд явж байхад энэ Идэрийн голын хойд талын Элс цогчины булан гэдэгт нэг шовойсон цагаан нэг ором байж байсан. Хажуугаар нь өнгөрсөн. Буцаад явахад байж л байсан. Тэр бол нэг л өдрийн ажил.Өглөө ирээд л орой буцахад. Тэгээд нэг намар Мэргэний цаад талд өнөөх чинь хурга хариулаад явж байтал, нэг өглөө хургаа гаргаад хариулж явтал, манай хойд талд хүрээд ирсэн бүүчихсан харагдсан. Өнөө зуны

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

үздэг, тэгээд л хургаа хариулчихаад хургаа хариулчихаад хүрээд ирсэн, тэр өдөр. Маргааш өглөө нь хургаа хариулаад гартал жаахан дөхөөд ирсэн байсан. Тэгэхлээр нь хургаа хариулангуут өнөөх чинь дөхөөд очсон чинь нэг дотор нь нэг том юм түн тан гэж дуугараад, хүн л дуугараад байдаг. Дөхөж очоод чагнаад, ингээд нэг муухай юм дотор хааяа хааяа хангинаж дуугараад л . Тэгэхээр нь өнөөдөхийг бүсээ урж дүүгүүр хийж дүүгүүрдээд, нөгөө шовгор оройгийг чинь. Онох онохгүй хэд дүүгүүрдчихээд. Тэгээд орхичихсон, юу байгаагийг нь ч мэдээгүй. Маргааш нь нэлээн өгсөөд буучихсан байсан, холдоод. Тэгээд л өнгөрсөн. Тэгэхээр нь тэр Дондогоо гэдэг хүн жарз хийж, зод тавьж явахад нь би зод гэрийг нь дүүхүүрдэж явсан юм билээ. Хойно нь тэр өвгөн надад тэгж ярьдаг байсан. Тэгээд тэрнээс сүүлд нэлээн хэд хоногийн дараа олон зодоч нийлж жинсрэг цутгаж байгаа гэж нэг лут юм болж байхыг очиж үзсэн. Олон зодоч нар зэрэгцээд суучихсан. Нэг их мод овоолчихсон, шар тос асгаад л , гал асаагаад л . Тэгээд л нижигнэтэл цөмөөрөө зод тавьж байхыг тийм юм үзсэн хүн дээ , би бас. Тэгж байсан юм, тэгэхэд би бага байсан. Тэгээд багын юмыг сайн мэдэхгүй юм. Яахав нэг онцлог онцлог юмнуудыг үзэж.

Билэг- Өрнөх: За танд баярлалаа.